



**ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ**

2021 оны 09 сарын 06 өдөр

Дугаар Б/64

Ховд

Ц.Лувсанлхамог ажилд түр томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.4, Төрийн албаны зөвлөлийн 2020 оны “Зохион байгуулалтын арга хэмжээ авах тухай” 01 дүгээр зөвлөмжийн 2 дугаар зүйлийн 2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ажлын зайлшгүй шаардлагаар Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн Үйлдвэр, худалдаа, үйлчилгээний асуудал хариуцсан мэргэжилтнээр Ц.Лувсанлхамог 2021 оны 09 дүгээр сарын 06-ны өдрөөс эхлэн тухайн ажлын байрны сул орон тоог Төрийн албаны тухай хууль, тогтоомжийн хүрээнд нөхөх хүртэл хугацаанд түр томилсугай.

2. Ажил хүлээлцэх ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

2. Ц.Лувсанлхамог удирдлага, арга зүйгээр хангаж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/-д үүрэг болгосугай.


3. Ц.Лувсанлхамог Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Төрийн захиргааны албан тушаалын цалингийн сүлжээ”-ний ТЗ-5-1 дэх шатлал буюу 642 388 төгрөг /Зургаан зуун дөчин хоёр мянга гурван зуун наян найм/-өөр цалинжуулахыг Санхүү, аж ахуйн тасгийн ерөнхий нягтлан бодогч /Б.Нямдэлгэр/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Д.ЭНХБОЛД

Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын  
2021 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн  
Б/64 дүгээр тушаалын хавсралт



**АЖИЛ ХҮЛЭЭЛЦҮҮЛЭХ АЖЛЫН ХЭСЭГ**

- Ажлын хэсгийн  
ахлагч: Б.Баярсүх - Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого,  
төлөвлөлтийн хэлтсийн дарга
- Гишүүд: Х.Болормаа - Санхүү, аж ахуйн тасгийн нярав
- Нарийн бичгийн  
дарга: Б.Түмэндэмбэрэл - Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого,  
төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

-оОо-